


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛЭЭС ХӨРӨНГӨ БОСГОХ АМАРХАН УУ

Г. Очцэцэг, МІСС-гийн шинжээч

2011-08-19

Сүүлийн жилүүдэд Монголын уул уурхайн салбар тэр дундаа ашигт малтмалын ордууд гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчидийн анхаарлыг ихээхэн татах болсоныг хэн бүхэн мэдэж байгаа. Үүнийг дагаад уул уурхайн компаниуд ч харьцангуй ихээр бий болж хайгуул, өрөмдлөгийн ажлууд эрчимтэй өрнөсөн. Гэтэл эдгээр компаниудын дийлэнх хувь нь гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан санхүүжилтээ босгосон гэдгийг тэр болгон хүмүүс мэддэггүй. Монголын хөрс шороонд хайгуул хийж Монгол газар нутаг дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа хэрнээ яагаад тэд гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргах болсон нь учиртай. Монгол орны дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 оны байдлаар 6 тэр бум ам.доллар байсан. Гэтэл Айванхоу Майнс ХК-ний зөвхөн Оюу Толгой төслийн зах зээлийн үнэлгээ гэхэд 13 тэр бум ам.доллар буюу Монголын ДНБ-ээс хоёр дахин их байгаа юм. Энэхүү харьцуулсан графикаас харахад Монголын ашигт малтмал уул уурхайн салбар



хөрөнгийн зах зээлээсээ хэд дахин илүү байгааг харж болно. Энэхүү харьцангуй зөрүүг уул уурхайн салбар өөрөө хайгуулын болон өрөмдлөгийн үе шатандаа асар их хэмжээний санхүүжилт шаарддагтай холбон тайлбарлаж болох юм.

МІСС компани нь гадаадын бирж дээр бүртгэлтэй Монголд олборлолт, хайгуулын ажил идэвхтэй хийж байгаа

компаниудын хувьцаануудын үнийн өөрчлөлтийг харуулах МІСС уул уурхайн индекс (MMI)-ийг 2005 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс олон улсын аргачлалаар тооцож ирсэн бөгөөд 2005 оны 8 дугаар сарын 1-ний өдрийг суурь үе болгон индексээ 100 пунктээр авч тооцдог.

Өнгөрсөн 6-н жилийн хугацаанд MMI нь хөрөнгө оруулагчдад танил болж Блүмберг болон Рейтерс зэрэг дэлхийн томоохон агентлагуудаар дамжин гадаадын хөрөнгө оруулагчидад хүрэх болсон. MMI-д Ivanhoe Mines, Centerra Gold, Hunnu Coal, Entrée Gold, Mongolian Mining Corporation, Petro Matad, Southgobi Resources зэрэг уул уурхайн олборлолт болон хайгуул хийдэг компаниуд ордог ба уг индексийг тооцохдоо зах зээлийн үнэлгээг Монголд оруулж буй хөрөнгө оруулалт болон үйл ажиллагаагаар нь тохируулга хийж, хувьцааны зах зээлийн үнэлгээгээр нь жигнэн тооцдог болно. Дээрх график нь индексийн сүүлийн 5-н жилийн үзүүлэлтийг харуулж байгаа ба эндээс Монголын уул уурхайн салбар 2008 оны санхүүгийн их хямралаас хойш эргэн хурдацтайгаар өсч байгааг харж болно.

